СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 29 өдөр Дугаар 1 Улаанбаатар хот

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("**Хурал**")-ыг 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн 12:00–14:00 цагт Zoom аппликэйшнээр хуралдсан бөгөөд Хурлын шууд нэвтрүүлэлтийг Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла Худалдааны Төв, 4-р давхарт, Өргөө 3 кино театр, 4-р танхимаас хийв.

Хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**")-ийн дарга А.Ганхуяг, Хурлын Тооллогын комиссоор Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтыг газрын захирал Н.Нарангэрэл (дарга), Брокер Н.Халиунгоо, Хөрөнгө оруулалтын шинжээч А.Намуун нар, Хурал зохион байгуулах комиссоор Санхүүгийн газрын захирал, Бизнес контроллер Д.Бүдханд (дарга), ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга, Маркетингийн газрын захирал Г.Батбаатар нар тус тус ажиллав. Хуралд ТУЗ-ийн ердийн гишүүд болох А.Ганболд, О.Батмөнх, Г.Бат-Эрдэнэ, Г.Чинзориг, Б.Бат-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүд болох Н.Энхболд, Гари Стивен Биондо нар оролцов.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 694,581,681 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 817,768,643 ширхэг энгийн хувьцааны 84.94 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлж Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 84.94 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, Хурлын дэг болон Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

(i) Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
(ii) Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
(iii) Компанийн 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах;
(iv) Компанийн зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх;
(v) Компаниас нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх;
(vi) Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх;
(vii) Компанийн нэмэлт өөрчлөлт орсон Дүрмийн төслийг батлах; болон
(viii) ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож дахин томилох.

Хурлын дарга Тооллогын комиссыг Хуралд санал өгөх журмыг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлаар хэлэлцэх 1, 3, 4, 5, 6 дугаар асуудлыг ердийн аргаар санал хураах ба хувьцаа эзэмшигчид нь эдгээр асуудалд "Зөвшөөрсөн", "Татгалзсан" эсвэл "Түдгэлзсэн" ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд ☑ тэмдэглэгээг хийж санал аа өгөх, харин Хурлаар хэлэлцэх 7 дугаар асуудлыг кумулятив аргаар санал хураах тул хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байж хувьцаа эзэмшигчид саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй тухай танилцуулав.

Хурлын дарга танилцуулах болон хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулахыг Хурал зохион байгуулах комиссын дарга болон Гүйцэтгэх захирлаас хүсэв. Хурал зохион байгуулах комиссын дарга нь Хуралтай холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох үүднээс Хурлын зарыг 2023 оны 03-р сарын 23-ны өдөр, давтан зарыг 2023 оны 04-р сарын 10-ны өдөр тус тус Өнөөдөр сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар, мөн Хурлын танилцуулга материал буюу Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2023 оны 03-р сарын 20-ны өдрийн 12 тоот тогтоол, Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэрийн төсөл, ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга, Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар болон Хуралд оролцож, санал өгөх зааврыг Компанийн цахим хуудаст байршуулж, брокерын компаниуд болох Голомт Капитал ХХК, Апекс Капитал ХХК-д хүргүүлснийг дурдаад дараахыг танилцуулав.

1. КОМПАНИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг Компанийн 2022 оны онцлох зүйлс, дэлгүүрийн тоо, үйлчлүүлэгчдийн тоо (давтагдсан), сүлжээ дэлгүүрийн борлуулалтын индекс, харьцуулагдахуй дэлгүүрийн борлуулалтын индекс, үйл ажиллагааны цар хүрээ, стратегийн зорилтууд, дэд бүтэц, дэлгүүрийн тэлэлт, хэвийн горимын түгээлтийн төв, хоолны үйлдвэрийн шугам, тоног төхөөрөмжийн сайжруулалт, хүйтэн хэлхээний төвийн автоматжуулалт, жижиглэн худалдааны үндсэн системийн сайжруулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгарал, байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан, санхүүгийн гүйцэтгэл, ашигт ажиллагааны харьцаа үзүүлэлтийг танилцуулав.

2. КОМПАНИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТИЙГ ТАНИЛЦУУЛАХ, ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

Компанийн хараат бус аудитор KPMG Audit ХХК-ийн Партнер Ким Сан Ён аудитын дүгнэлт, юунд аудит хийсэн талаар, дүгнэлтийн үндэс, хараат бус байдал, аудитын арга барил, аудитын гол асуудлууд болон бусад мэдээлэл гэсэн сэдвийн хүрээнд Компанийн 2022 оны санхүүгийн жилийн тайлангийн хараат бус аудиторын тайланг; Хурал зохион байгуулах комиссын дарга Компанийн 2022 оны санхүүгийн жилийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг тус тус танилцуулав. Дээрх танилцуулсан асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй.

3. КОМПАНИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)-ААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ШАЛТГААН

Компанийн 2022 оны санхүүгийн тайланд үндэслэн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ногдол ашгийн бодлогын дагуу Компанийн ТУЗ-өөс 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн 17 тоот тогтоолоор 2022 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Компанийн 2021 оны үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Компани ашигтай ажилласан жилээс эхлэн ногдол ашиг хуваарилахыг ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. 2022 оны санхүүгийн үр дүнгээр Компани алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гаргасан тухай Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байгаа эсэхийг тодруулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй.

4. КОМПАНИЙН ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦААНЫ ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Компани нь 2021 онд олон нийтэд хувьцаагаа гаргахдаа 360 хүртэл дэлгүүрийн тэлэлт болон дэд бүтцийн өргөтгөлийг санхүүжүүлэх зорилготой гаргасан бөгөөд зорилтот дэд бүтцийн тэлэлтүүдийг амжилттай хийж, 2023 онд 360 дэлгүүр нээнэ. Компани нь цаашдын тэлэлтэд зориулан санхүүжилт татах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн дараагийн шатны өргөтгөлийн төслүүдийг хийхэд нэмэлт хөрөнгө оруулалт,

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх замаар нэмэлт хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх зорилгоор Компани зарласан энгийн хувьцааныхаа тоог 50,956,877-р нэмэгдүүлэх асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байгаа эсэхийг тодруулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй.

5. КОМПАНИЙН НЭМЖ ГАРГАХ ЭНГИЙН ХУВЬЦААГ ТЭРГҮҮН ЭЭЛЖИД ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ЭДЛҮҮЛЭХГҮЙ БАЙХ

Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулсан бөгөөд Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалтын дагуу Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргах энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй; Компани нь өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагад үндэслэн энгийн хувьцаа нэмж гаргах тохиолдолд, хувьцаа нэмж гаргах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах зорилгоор Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дах заалтын дагуу Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх саналыг оруулж байгаа тухай тайлбарласан бөгөөд нэмж зарласан хувьцаанаас 49,038,500 ширхгийг стратегийн хөрөнгө оруулагч болох Премиум Групп ХХК-д нэгж хувьцааг сүүлийн 6 сарын дундаж зах зээлийн үнээс 26 хувиар өндөр үнээр буюу 208 төгрөгөөр худалдаж, хаалттай хүрээнд нэр заан эзэмшүүлэх эрхийг ТУЗ Компанийн дүрмийн 9.4.4-т заасны дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тухай танилцуулаад хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байгаа эсэхийг тодруулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй.

6. КОМПАНИЙН ОРШИН БАЙГАА ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ

Компанийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт шилжүүлсэнтэй холбогдуулан Компанийн оршин байгаа хаягийг өөрчилж Компанийн Дүрэмд тусгах асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулж хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байгаа эсэхийг тодруулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй.

7. КОМПАНИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ДҮРМИЙН ТӨСЛИЙГ БАТЛАХ

Компанийн зарласан энгийн хувьцааны тоо болон Компанийн оршин байгаа хаягт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах тухай асуудлыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулж хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт байгаа эсэхийг тодруулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй тул Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв. Санал хураалт 5 минут үргэлжлэв.

8. КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

Компанийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн 9-н гишүүнтэй, гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүн агсан Ч.Мэргэн нас барсан тул түүний оронд В.Ганзоригийг ТУЗ-өөс түр томилсонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож шинэ бүрэлдэхүүнээр буюу А.Ганхуяг, А.Ганболд, Г.Бат-Эрдэнэ, О.Батмөнх, Б.Бат-Эрдэнэ, Г.Чинзориг нарыг ТУЗ-ийн ерийн гишүүнд, Н.Энхболд, В.Ганзориг, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж байгаа тухай болон нэр дэвшиж буй гишүүдийн товч намтрыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав. Дээрх асуудлуудтай холбоотой асуулт хувьцаа эзэмшигчдээс ирээгүй тул Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах: зөвшөөрсөн 694,455,449 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 ширхгээр нэмэгдүүлж, нийт 900,716,470 ширхэг болгох: зөвшөөрсөн 694,434,468 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 3,275 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 17,706 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

3. Компани нь зарласан хувьцааны тоонд багтаан энгийн хувьцаа нэмж гаргахад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэх: зөвшөөрсөн 694,422,224 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 31,074 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,151 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

4. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрөх: зөвшөөрсөн 694,452,615 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,834 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

5. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг хавсралт ёсоор батлах: зөвшөөрсөн 694,452,615 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 2,834 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.

6. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр өгсөн саналын тоо нь дор дурдсан тоо хэмжээтэй байна.

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын хувь
	Ердийн гишүүд		
1	Адилбишийн Ганхуяг	694,494,549	11.11 %
2	Адилбишийн Ганболд	694,478,759	11.11 %
3	Гансүхийн Бат-Эрдэнэ	694,458,759	11.11 %
4	Очирбатын Батмөнх	694,465,759	11.11 %
5	Ганболдын Чинзориг	694,634,094	11.11 %
6	Болдбаатарын Бат-Эрдэнэ	694,465,759	11.11 %
	Хараат бус гишүүд		
1	Нямжавын Энхболд	694,368,759	11.11 %
2	Ванчигийн Ганзориг	694,355,482	11.11 %
3	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)	694,377,121	11.11 %

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийн 2022 оны тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“**Компани**”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал

("**Хурал**")-ын шийдвэр болон Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

Тогтоол 2: Зарласан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай
Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дох заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн зарласан энгийн хувьцааны тоог 50,956,877 (Тавин сая есөн зуун тавин зургаан мянга найман зуун далан долоон) ширхгээр нэмэгдүүлж, нийт 900,716,470 (Есөн зуун сая долоон зуун арван зургаан мянга дөрвөн зуун далан) ширхэг байхаар тогтоосугай.

2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг) нарт үүрэг болгосугай.

Тогтоол 3: Компанийн нэмж гаргах энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай
Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дах заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дах заалт, 76 дугаар зүйлийн 76.1.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь зарласан хувьцааны тоонд багтаан энгийн хувьцаа нэмж гаргахад хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн Дүрэмд заасан зарласан хувьцаанаас нэмж гаргах хувьцааны тоо ширхэг, нийтэд санал болгох хугацааг тодорхойлох зэрэг хувьцаа нэмж гаргахтай холбоотой бусад шийдвэрийг тухай бүр гаргаж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй болохыг дурдсугай.

Тогтоол 4: Компанийн оршин байгаа хаягийг өөрчлөх тухай
Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дах заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хэмээн өөрчилж Компанийн Дүрэмд тусгахыг зөвшөөрсүгэй.

2. Компанийн оршин байгаа хаягийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Тогтоол 5: Компанийг нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төслийг батлах
Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн нэмэлт өөрчлөлт орсон дүрмийн төсөл ("**Дүрэм**")-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Компанийн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Тогтоол 6: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04-р сарын 29-ний өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**")-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
   (i) Адилбишийн Ганхуяг,
   (ii) Адилбишийн Ганболд,
   (iii) Гансүхийн Бат-Эрдэнэ,
   (iv) Очирбатын Батмөнх,
   (v) Болдбаатарын Бат-Эрдэнэ,
   (vi) Ганболдын Чинзориг.

2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
   (i) Нямжавын Энхболд,
   (ii) Ванчигийн Ганзориг,
   (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).

3. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Ийнхүү танилцуулаад Хурлын дарга Хурлыг хаав.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ХУРЛЫН ДАРГА





CENTRAL EXPRESS CVS JSC
СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК
УЛААНБААТАР ХОТ
9022010245 6155804 ШЖР0471

_____ А.ГАНХУЯГ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:  ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга